

НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ САНАЛ

Р. Хатанбаатар, Л. Батжав (Ph.D)

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын хүсэлтээр нийслэлийн эрх зүйн тухай хуулийн төсөл дэх дүүргийн эрх мэдлийг өргөтгөх асуудлаар судалгаа хийж дараах дүгнэлтэд хүрэв.

- Хүчин төгөлдөр үйлчилж буй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын хууль дахь дүүргийн эдийн засгийн эрх мэдэл, өнөөгийн байдал, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломж, тухайлбал төсөв, татвар, өмч, газрын харилцааны талаарх заалт нь үйл ажиллагаа явуулахад боломжтой, ямар нэгэн хязгаарлалтгүй гэж үзэж байна.
- Мөн түүнчлэн нийслэлийн эрх зүйн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэх дүүргийн санхүүгийн эрх мэдэл, дүүргийн удирдлагаас иргэд, аж ахуйн нэгж болон төрийн захиргааны төв байгууллагатай харьцах асуудлын талаарх заалтууд нь дүүрэг хэвийн үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн байдлаар саад болохгүй гэж үзэж байна.

Дүүргийн төсвийн татварын орлогыг бүрдүүлэх суурийг өргөтгөх нь дүүргийн санхүүгийн харьцангуй бие даасан байдлыг тодорхой хэмжээгээр дээшлүүлэх талтай байж болох юм. Тухайлбал, Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуульд доохи чиглэлээр зарим өөрчлөлт оруулж болох юм.

- Бодит байдал дээр дүүргийн төсвийн татварын орлогыг бүрдүүлдэг бууны албан татвар, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж, байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж, байгалийн ургамал ашигласны төлбөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ус, рашаан ашигласны төлбөр, орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварууд нь дүүргийн төсвийн бүрдүүлэлтэд өчүүхэн хэсгийг эзэлж байна.
- Нийслэлийн дүүргүүд нь аймагуудтай харьцуулахад хүн, ам, нийгэм, эдийн засгийн бүтцийн хувьд дийлэнх үзүүлэлтүүдээр адил буюу илүү байгаа тул Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль дахь нийслэлийн төсвийг бүрдүүлж буй хотын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын зохих хэсгийг шууд дүүрэгт төвлөрүүлэх саналтай байна.
- Цаашилбал дүүрэгт төвлөрүүлэх ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, нөөц ашигласны төлбөрийн хувийг нэмэгдүүлэх нь дүүргийн санхүүд чухал гэж үзэж байна.
- Хуулийн төсөлд тусгасан татваруудаас гадна дархан цаазат бүс нутагт оршиж суугчдаас авах тусгай төрлийн татвар, агаар бохирдуулсны татвар зэргийг шинээр оруулах саналтай байна.

Ер нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль нь санхүүгийн хэт төвлөрөл үүсгэж орон нутгийн, түүний дотор дүүргийн бие даасан байдлыг хангах, эдийн засгийн бие даах санхүүгийн хөшүүргийг бүрдүүлж чадахгүй байгаа нь нэгэнт тодорхой

байгаа тул уг хуулийг шинэчлэх асуудал бол нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах гол хөшүүрэг болоод байна.

Энэхүү судалгааг хийхдээ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Нийслэлийн эх зүйн байдлын тухай хууль болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн агуулга, мөн чанар, онцлогийн харьцуулалтыг задлан шинжлэж, нэгтгэн дүгнэж, бичиг баримтын судалгаа хийв.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН